

**“МОНГОЛ ДААТГАЛ” ХХК-ИЙН ИРГЭДИЙН ГЭНЭТИЙН ОСЛЫН
ХҮРТЭЭМЖТЭЙ ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МЭДЭЭЛЭЛ**

2018 оны 05 дугаар сарын 12

№	Мэдээлэл	Иргэдийн гэнэтийн ослын даатгал
1	Даатгалын зүйл:	<ul style="list-style-type: none"> ➤ 18-аас дээш насны иргэд ➤ 18 хүртэлх насны хүүхэд
2	Даатгалын эрсдэлийн төрөл:	<ul style="list-style-type: none"> ➤ Бүх төрлийн гэнэтийн ослын улмаас даатгуулагч нас барах ➤ Бүх төрлийн гэнэтийн ослын улмаас даатгуулагч хөдөлмөрийн чадвараа алдах
3	Даатгалын үнэлгээний дүн:	<ul style="list-style-type: none"> ➤ 1 000 000 төгрөг
4	Даатгалын хураамжийн дүн /хувь/:	<ul style="list-style-type: none"> ➤ 5 000 төгрөг /0.5%/
5	Өөрийн хүлээх хариуцлага:	<ul style="list-style-type: none"> ➤ Байхгүй
6	Даатгалын гэрээний үргэлжлэх хугацаа:	<ul style="list-style-type: none"> ➤ 1 жил
7	Даатгагчийн эрх, үүрэг:	<ul style="list-style-type: none"> ➤ Даатгагч нь дараах эрхтэй. Үүнд: <ul style="list-style-type: none"> ➤ Даатгуулагчийн эрх, үүрэг нь шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулах саналыг шинэ эзэмшигчид тавих; ➤ Шаардлагатай гэж үзвэл даатгалын зүйлтэй дэлгэрэнгүй танилцах; ➤ Даатгуулагч аюулыг санаатайгаар ихэсгэсэн бол даатгагч гэрээг цуцлах саналыг нөгөө талд тавих; ➤ Даатгалын тохиолдол бий болсон тохиолдолд түүний шалтгаан, нөхцөлийг судлах, эрх бүхий байгууллагаар шалгуулах, шаардлагатай мэдээ, мэдээллийг Даатгуулагчаас шаардах; ➤ Даатгалын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Даатгуулагчаас шаардах; ➤ Даатгагч нь дараах үүрэгтэй. Үүнд: <ul style="list-style-type: none"> ➤ Даатгалын хууль тогтоомж, даатгалын нөхцөлүүдийг даатгуулагчид танилцуулах, өөрийн санхүүгийн чадавхын талаарх мэдээллийг Даатгуулагчид өгөх; ➤ Гэрээнд өөрөөр заагаагүй бол Даатгалын тохиолдол бий болсны улмаас учирч болох хохирлын хэмжээг багасгахын төлөө даатгуулагчийн авсан арга хэмжээний өртгийг даатгалын нөхөн төлбөр дээр нэмж даатгуулагчид нөхөн төлөх; ➤ Даатгалын нөхөн төлбөрийг энэхүү гэрээнд заасны дагуу Даатгуулагчид олгох; ➤ Хохирлын хэмжээг үнэн зөв тогтоох зорилгоор Даатгуулагчтай бүх талаар идэвхтэй хамтран ажиллах.

8	Даатгуулагчийн эрх, үүрэг	<ul style="list-style-type: none"> ➤ Даатгуулагч нь дараах эрхтэй. Үүнд: <ul style="list-style-type: none"> ➤ Даатгалын тохиолдол болсон үед гэрээний нөхцөлийн дагуу нөхөн төлбөр олгохыг даатгагчаас шаардах; ➤ Даатгагч шаардлагатай гэж үзвэл даатгалын зүйлийг даатгагчийн ажилтанд дэлгэрэнгүй танилцуулах; ➤ Даатгагч хууль болон гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах болон түүнд өөрчлөлт оруулахыг шаардах; ➤ Даатгуулагчийн эрх үүрэг шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд шинэ эзэмшигч энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах саналыг даатгагчид тавих; ➤ Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд даатгагчийн санхүүгийн чадавхын талаар холбогдох мэдээ, мэдээлэл шаардах; ➤ Даатгагчийн санхүүгийн чадвар муудсан гэж үзэх хангалттай үндэслэл бий болсон тохиолдолд гэрээг цуцлах саналыг нөгөө талд тавих; ➤ Даатгалын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Даатгагчаас шаардах; ➤ Хохирлын хэмжээг үнэн зөв тогтоох зорилгоор Даатгагчтай бүх талаар идэвхтэй хамтран ажиллах; ➤ Даатгуулагч нь дараах үүрэгтэй. Үүнд: <ul style="list-style-type: none"> ➤ Даатгуулагч даатгалын хураамжийг энэхүү даатгалын гэрээ, баталгаа байгуулагдсан даруй даатгагчид төлөх; ➤ Даатгал болон даатгалын зүйлтэй холбоотой баримт, материал ба даатгалын тохиолдол бий болсон үед энэхүү гэрээ болон даатгалын нөхцөлүүдэд тусгагдсан баримт материалыг даатгагчид үнэн зөв, бүрэн гүйцэд, хууль зүйн дагуу бүрдүүлэн, даатгалын тохиолдол бий болсон өдрөөс хойш хуанлийн 90 хоногийн дотор хүлээлгэн өгөх; ➤ Даатгалын зүйлийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгалын тохиолдол болсон үед хохирлыг багасгах зорилгоор бололцоотой бүх арга хэмжээг авах; ➤ Даатгалын тохиолдол болсон тухай даатгагчид даатгалын тохиолдол болсноос хойш Улаанбаатар хотод бол нэн даруй, орон нутагт бол 72 цагийн дотор даатгагчийн 1800-1990 дугаарын утсанд урьдчилан мэдэгдэх; ➤ Даатгалын тохиолдол бий болсон үед энэхүү гэрээнд тусгагдсан баримт, материалыг өөрийн зардлаар бүрдүүлэн даатгагчид хүлээлгэн өгөх; ➤ Даатгуулагч нь гэрээ байгуулахдаа өөрийн мэдэж байгаа аюул учруулах буюу даатгалын тохиолдол бий болоход нөлөөлж болох ноцтой нөхцөл байдал, түүнчлэн гэрээ байгуулснаас хойш шинээр бий болсон нөхцөл байдал, эрсдэлийн орчны өөрчлөлт, даатгалын тохиолдол бий болох боломжтой нөхцөл орчин бүрдсэн тухай даатгагчид нэн даруй мэдээлэх; ➤ Энэхүү гэрээнд заагдсан бусад үүрэг; ➤ Даатгалын тохиолдлоор хүний амь нас хохирсон бол энэ тухай
---	---------------------------	--

		<p>даатгагчид 48 цагийн дотор 1800-1990 утсанд урьдчилан мэдэгдэх;</p> <ul style="list-style-type: none"> ➤ Даатгуулагч нь гэрээ байгуулахдаа өөрийн мэдэж буй эрсдэлийн нөхцөл байдал түүнчлэн нас, хүйс, эрүүл мэндийн байдал архаг хууч өвчний талаар бүхий л мэдээллээр үнэн зөв хангах; ➤ Даатгуулагч нь даатгалын тохиолдол болмогц яаралтай эмнэлэгт хандан гэмтэл бэртлийг даамжруулж хүндрүүлэлгүй эмчилгээ үйлчилгээ хийлгүүлэх
9	Даатгалын нөхөн төлбөр олгоход бүрдүүлэх материал:	<ul style="list-style-type: none"> ➤ Даатгалын гэрээ, баталгааны эх хувь; ➤ Нөхөн төлбөр олгохыг хүссэн өргөдөл; ➤ Эмнэлгийн карт буюу даатгуулагчийн өвчний түүх бүхий баримт бичиг, рентген зураг; ➤ Даатгуулагч нас барсан бол нас барсны гэрчилгээ; ➤ Даатгуулагч хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар алдсаныг тогтоосон эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын акт, дүгнэлт; ➤ Даатгуулагч эмчилгээ хийлгүүлсэн болохыг баталгаажуулсан эмнэлгийн хуудас буюу лист, бусад нотлох бичиг баримт; (уг баримтанд даатгуулагчийн овог нэр, өвчлөл гэмтлийн онош, эмчлүүлсэн хугацааг тодорхой зааж тамга тэмдгээр баталгаажуулсан байна); ➤ Гэр бүлийн гишүүн даатгагдсан тохиолдолд гэрлэлтийн гэрчилгээ эсвэл хүүхдийн төрсний гэрчилгээ; ➤ Шаардлагатай гэж үзвэл эмчлэгч эмчийн дүгнэлт, тодорхойлолт
10	Даатгалын нөхөн төлбөр олгох хугацаа:	<ul style="list-style-type: none"> ➤ Ажлын 10 өдөр
11	Даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзах нөхцөл:	<ul style="list-style-type: none"> ➤ Даатгуулагчийн даатгалд хамрагдахаас өмнө учирсан осол, өвчний улмаас олсон гэмтлийн урхаг, хор нөлөөнөөс үүдэлтэй хохирол; ➤ Даатгуулагч нь санаатайгаар өөрийн биед гэмтэл учруулсан, амиа хорлосон, амиа хорлохыг завдсанаас үүдсэн хохирол; ➤ Даатгуулагч хууль бус гэмт хэргийн шинж чанар, зорилгоор үйлдсэн үйлдлийн улмаас учирсан хохирол; ➤ Даатгуулагч согтууруулах ундаа, мансууруулах бодис, хориотой эм бэлдэл хэрэглэснээс үүдсэн болон сэтгэцийн өвчин, эмгэгийн улмаас учирсан хохирол; ➤ Гэрээнд зааснаас бусад эрсдэлээр учирсан хохирол, бүх төрлийн өвчин эмгэгийн улмаас үүдсэн хохирол;
12	Даатгуулагч даатгалын гэрээнээс татгалзах тохиолдолд даатгуулагчид даатгалын хураамжийн буцаалтыг тооцож, олгох нөхцөл:	<ul style="list-style-type: none"> ➤ Хэрэв даатгуулагч даатгагчаас нөхөн төлбөр аваагүй бөгөөд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас даатгалын гэрээг цуцлах хүсэлт гаргасан нөхцөлд даатгагч гэрээний хүчинтэй хугацаанд ногдох хураамжийн буцаалтыг олгохдоо нийт даатгалын хураамжаас гэрээний ашигласан хугацаанд ногдох даатгалын хураамж болон даатгалтай холбогдон гарсан зардлыг хасч буцаалтыг олгоно.